

**ПҮҮЛЭГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН  
АЖЛЫН ДААЛГАВАР**

№	АГУУЛГА	
1	Зорилго	Компанийн Салбарын нүүрс ачилт, ложистикийн хэлтсийн ажилтнуудыг мэргэшүүлэх, хөгжүүлэх.
2	Зорилт	<ol style="list-style-type: none"> <li>1. Хэрэгцээг тодорхойлж чанартай, үр дүнтэй сургалтыг зохион байгуулах;</li> <li>2. Судалгаа авч, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гаргах;</li> <li>3. Шаардлагатай программ дээд ажиллуулж, дадлагажуулах;</li> <li>4. Ажилтны мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх.</li> </ol>
3	Хэрэгцээ, шаардлага	Компанийн салбарын үйл ажиллагаа өргөжиж, ажлын ачаалал нэмэгдэж, ажилтнуудыг мэргэшүүлэх шаардлага гарсан.
4	Сэдэв	<p>Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хэмжил зүйн онол;</li> <li>• Хэмжил зүйн хууль, эрх зүй;</li> <li>• Массын хэмжлийн онол, бүтэц, зарчим, арга зүй;</li> <li>• Truck Scaling system-ийн мэдлэгийг сэргээж, бататгах;</li> <li>• Дадлага ажил болон бусад</li> </ul>
5	Хэлбэр	Онол болон практик хосолсон байдлаар
6	Тавигдах шаардлага	<p><u>Сургалтын байгууллагад:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрх бүхий байгууллагаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх;</li> <li>• Тухайн чиглэлээр 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай;</li> <li>• Сүүлийн 3 ба түүнээс дээш жил уурхайн салбарт тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай;</li> <li>• Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалтыг явуулах;</li> <li>• Сургалтын өөрийн анги, танхим, техник, тоног төхөөрөмжтэй байх;</li> <li>• Сургалтыг хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах;</li> <li>• Тухай сургалтын агуулга, хугацаа, хамрах хүрээ зэргээс шалтгаалан мэргэжлийн багш нартай байх;</li> <li>• Сургалтад хамрагдсан ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх олгох</li> </ul> <p><u>Сургагч багшид:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургагч багш нь тухайн чиглэлийн мэргэжлийн бөгөөд мэргэшсэн байх;</li> <li>• Сургагч багш нь тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;</li> <li>• Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх;</li> <li>• Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах.</li> </ul>
7	Хамрах хүрээ	Салбарын Нүүрс ачилт, ложистикийн хэлтсийн ажилтнууд /пүүлэгч 20 ажилтан/
8	Хугацаа	<p>2020 оны 3 дугаар сард</p> <p>24-40 академик цаг /сургалтын агуулгаас шалтгаалан сургалтын цагийг нэмж, хасах боломжтой/</p>

		“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ээлжийн хуваариас шалтгаалан сургалтыг давтамжтай явуулах
9	Төсөв	Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн болон бусад зардал
10	Байршил	Улаанбаатар хот болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Салбарт
11	Үр дүн	Ажилтнууд тухайн мэргэжлээрээ мэргэшиж, ажлын үр дүн, бүтээмж нэмэгдэнэ.